



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/488

Мандалговь

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс ажиллуулах тухай

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нэгдсэн халаалтын уурын зуух, гадна халаалтын шугамын ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Ж.Мөнхчулуун	(Аймгийн Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга:	О.Мөнхзул	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө, оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
Гишүүд:	Д.Нэргүй	(Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)
	Н.Эрдэнэбат	(Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)
	Б.Золжаргал	(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүч, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч)
	Э.Цэрэннадмид	(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагч)
	Б.Доржхорол	(Аймгийн Онцгой байдлын газрын мэргэжилтэн)
	А.Бямбаа	("Мандал харш" ХХК-ний инженер)
	О.Ганбат	("Ган-Илч" ХХК-ний ерөнхий захирал)
	Э.Дашням	("Ган-Илч" ХХК-ний ашиглалтын инженер)
	Т.Түмэнжаргал	(БЗӨБ ТӨХК-ний Говьсүмбэр ЦТСС-ын Цагаандэлгэр сумын монитор)
	Д.Буджав	(Цагаандэлгэр сумын Засаг дарга)
	П.Алтанчимэг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)

488010595

Хоёр. Угсралтын ажлыг хууль, дүрмийн дагуу ажиллаж, зураг, төслийн дагуу гүйцэтгэсэн байдалд дүгнэлтийг гарган, архивт хүлээлгэн өгч мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэхийг комисс (Ж.Мөнхчулуун)-д даалгасугай.

Гурав. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/270 дугаартай захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ